



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 8 дугаар сарын 24-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар А-105 ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журам-ыг 1 дүгээр, Гарал үүслийн гэрчилгээний загварыг 2 дугаар, Таримлын кодыг 3 дугаар, Талбайн түүхийн дэвтрийн загварыг 4 дүгээр, Гарал үүслийн гэрчилгээ олгоход баримтлах хугацааг 5 дугаар, Тариаланч иргэний баталгааны тэмдгийн загварыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ц.Болорчулуун)-т үүрэг болгосугай.

3. Журмыг Хууль зүйн яаманд хүргүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Төрийн захиргааны удирдлагын газар (О.Амгаланбаатар)-т даалгасугай.

САЙД

Р.БУРМАА

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015
оны 8 дугаар сарын 24-ны өдрийн

А-105 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**УРГАМАЛ, ТҮҮНИЙ ГАРАЛТАЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛ
МӨРИЙГ МӨРДӨН ТОГТООХ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчдээс зах зээлд бэлтгэн нийлүүлж буй ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, таримал ургамлын үр, суулгацын гарал үүслийг тогтоох, хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор бүртгэл, хяналтын тогтолцоо, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг таримал болон байгалийн ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлд борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээд, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон бүх шатны мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчид дагаж мөрдөнө.

1.3. Зөвхөн гэр бүлийн хэрэгцээндээ зориулан тариалсан, хураасан, түүсэн таримал болон байгалийн ургамал түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн энэхүү журамд үл хамаарна.

1.4 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог хуульд тодорхойлсны дагуу дор дурьдсан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.4.1. “анхан шатны үйлдвэрлэл эрхлэх” гэж - хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.7-д заасныг;

1.4.2. “таримал ургамал” гэж – ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.2-д заасныг;

1.4.3. “үр” гэж –таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 3.1.2-д заасныг;

1.4.4 “ургамлын өвчин” гэж – ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.4 –д заасныг;

1.4.5 “хөнөөлт шавж” гэж – ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.5 –д заасныг;

1.4.6 “хөнөөлт мэрэгч амьтан” гэж - ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.6–д заасныг;

1.4.7 “ургамал хамгаалах бодис” гэж – Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.8-д заасныг.

1.5. Хог ургамал гэдэгт тухайн талбайд тариалж буй ургамлаас өөр ургамлыг ойлгоно.

1.6. Ургамал, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гэж тариалангийн үйлдвэрлэлд болон хүнс, тэжээлд хэрэглэх, борлуулах, зориулалт бүхий таримал болон байгалийн ургамал түүний үр, жимс, цэцэг, иш, навч, үндэс, тарьц, суулгацыг ойлгоно.

**Хоёр. Зах зээлд борлуулах ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд,
бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох гарал үүслийг бүртгэж
гэрчилгээжүүлэх**

2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь дор дурдсан иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг нь харгалзан энэхүү журамд заасан дагуу гарал үүслийг хянан бүртгэж гэрчилгээ олгоно. Үүнд:

2.1.1.Өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд ургуулсан ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд худалдах гэж байгаа, тухайн сумын харъяат иргэн хуулийн этгээд,

2.1.2.Тухайн талбай түүнийг өмчлөгч, эзэмшигчтэй нь бичгээр байгуулсан гэрээний дагуу түрээсээр эзэмшиж, ашиглаж байгаа талбайд ургуулсан ургамал түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ зах зээлд худалдан борлуулах гэж байгаа иргэн хуулийн этгээд,

2.1.3.Худалдан борлуулах зорилгоор байгалийн ургамал (жимс, самар, мөөг эмийн ургамал) түүсэн иргэн, хуулийн этгээд.

2.2.Газар эзэмшигч, өмчлөгчтэй тариалан эрхлэх тухай албан ёсны гэрээ хийгээгүй, гэрээ хийсэн боловч түүнийгээ уг сумын тамгын газарт албан ёсоор бүртгүүлээгүй бол уг талбайд ургуулсан бүтээгдэхүүний бүртгэлийн гэрчилгээг зөвхөн тухайн талбайг өмчлөгч, эзэмшигчид олгоно.

2.3.Зах зээлд бүтээгдэхүүнээ худалдахыг хүссэн анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч нь энэ тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан талбайн түүхийн дэвтрийг тогтмол хөтөлсөн байна.

2.4.Талбайн түүхийн дэвтэргүй, дэвтэртээ зохих тэмдэглэлийг хөтлөөгүй иргэн, хуулийн этгээдэд уг талбайгаас хураасан ургацыг зах зээлд нийлүүлэхэд гарал үүслийн гэрчилгээ олгохгүй.

2.5.Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулахыг хүссэн иргэн нь Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”-ын дагуу тариаланч иргэний баталгааны тэмдгийг энэ журмаар баталсан загвараар хийлгэсэн байна.

2.6.Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг тариаланч иргэний баталгааны тэмдгийн дардас нь тухайн аймаг, сум, багийн код болон иргэний овог, нэр, регистр, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн санд бүртгүүлсэн дугаар бүхий зууван дугуй хэлбэртэй байна.

2.7. Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэгч иргэн нь худалдах бүтээгдэхүүнийхээ гэрчилгээн дээр иргэний баталгааны тэмдэг, хуулийн этгээд нь аж ахуйн нэгжийн тэмдэгийг дарсан байна.

Гурав. Зах зээлд борлуулах ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал, үүслийн гэрчилгээ, түүний код

3.1. Зах зээлд худалдах зориулалтаар бэлдсэн, чанар, хорио цээр, аюулгүй байдлын шаардлага хангасан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгоно.

2. Сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь “Ургамал хамгааллын тухай” хуулийн 13.2.2 дахь заалтыг үндэслэн хүнс, тэжээлийн дор дурьдсан 7 төрлийн ургамал, 6 төрлийн таримлын үр, суулгацыг бүртгэж, гарал үүслийн гэрчилгээ олгоно.

Нэг: Ургамал

1. Үр тариа, тэжээлийн таримал

2. Төмс

3. Хүнсний ногоо

4. Буурцагтан

5. Тос техникийн ургамал

6. Жимс, жимсгэнэ

7. Байгалийн ургамал

8. Бусад

Хоёр: Таримлын үр, суулгац

9. Үр тариа, тэжээлийн таримлын үр

10. Төмсний үр

11. Хүнсний ногооны үр

12. Буурцагтаны үр

13. Тос, техникийн ургамлын үр

14.Жимс, жимсгэний суулгац

15.Бусад үр г.м

3.3.Бусад ургамал гэдэгт шинээр нутагшиж, тарималжсан зах зээлд борлуулах дээрхи бүлэгт багтахгүй /эмийн, чихрийн болон олсны гэх мэт/ ургамлыг ойлгоно.

3.4.Зах зээлд борлуулах ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гэрчилгээний хуудас нь энэхүү тушаалаар баталсан загвараар хэвлэсэн маягт байх ба “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээний код”-ын тэмдэглэгээнд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” /MNS5641-0-2006, MNS5641-1-2006, MNS5641-2-2006, MNS5641-3-2006 стандарт/-ыг ашиглах бөгөөд 6 оронтой тоо байна.

3.5.Дараагийн 5 орон нь анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчдэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас олгосон дугаар байна.

3.6.Ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний таримлын код нь 2 оронтой, таримлын үр, суулгац нь 2 оронтой тоо байна. (хавсралт-3)

Тайлбар жишээ. 65-Архангай аймаг, 01-Эрдэнэбулган сум, 51-Эрдэнэбулган сумын 1 дүгээр баг. 26845- анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчийн код, 1.1 – буудай, 9.1- буудайн үр .

3.7.Зах зээлд борлуулах ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээний загвар энэхүү журмын 2 дугаар хавсралтад зааснаас өөр байж болохгүй. Энэ журамд зааснаас өөрөөр хэвлэсэн гэрчилгээг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

Дөрөв. Зах зээлд борлуулах ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох гарал үүслийн

гэрчилгээг олгох, хэрэглэх

4.1. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын газар тариалангийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь гарал үүслийн гэрчилгээ олгохдоо борлуулах гэж буй тухайн түүхий эд, бүтээгдэхүүнд гадаад өнгө, үнэр, бүтэц өөрчлөгдсөн, ялзарч муудсан, хортон шавж, түүний авгалдай, хүүхэлдэй, хог ургамлын үр, механик хольц, байгаа эсэхэд мэдрэхүйн үзлэг хийж, талбайн түүхийн дэвтрийн тэмдэглэлийг нь үндэслэнэ.

4.2. Шаардлагатай тохиолдолд ургамал, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийлгэсний дараа гэрчилгээ олгож болно.

4.3. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын газар тариалангийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох гарал үүслийн гэрчилгээг уг бүтээгдэхүүний биологи, хими, физикийн шинж чанар болон аж ахуйн шинж чанарыг харгалзан энэ тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан хугацааг баримтлан олгоно.

4.4. Гэрчилгээнд заасан хугацаа нь дууссан түүхий эд, бүтээгдэхүүнд дахин үзлэг хийж гэрчилгээг шинээр олгоно.

4.5. Гэрчилгээг 3 хувь үйлдэж, 1 хувийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн хадгалах ба 2 хувийг уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид олгоно. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь хүнсний сүлжээний дараагийн шатны үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийг дагалдуулан 1 хувийг өгч, 1 хувийг өөртөө хадгална.

4.6. Нэг нэр төрлийн код, гарал үүсэл, чанартай бүтээгдэхүүнд тоо хэмжээг харгалзахгүйгээр нэг дугаартай гэрчилгээ олгох ба олон газарт борлуулах нөхцөлд гэрчилгээг хувилан олгоно. Хувилсан гэрчилгээг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч өөрийн тэмдэг, баталгааны тэмдгээр баталгаажуулна.

4.7. Тариаланч иргэн, хуулийн этгээд нь гэрчилгээний хувь бүр дээр тариаланч иргэний баталгааны тэмдэг /хуулийн этгээдийн тэмдэг/ дарсан байна.

4.8. Тариаланч иргэн, хуулийн этгээдийн тэмдгийн дардасгүй болон хувилсан дардастай гэрчилгээг хүчингүйд тооцно.

4.9. Орон нутгаас нийлүүлэгдэж буй ургамал, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд тухайн зах, худалдааны газрын дэргэдэх дотоод хяналтын лаборатори нь энэ журмын 4.1-д заасан гарал үүслийн гэрчилгээг шалгаж баталгаажуулан энэ тухай тэмдэглэгээ хийнэ.

4.10. Хүнсний худалдааны төвийн дэргэдэх дотоод хяналтын лаборатори нь орон нутгаас олгосон гэрчилгээг хураан авч бүртгэл хөтөлж, архивлан хадгална.

4.11. Гарал үүслийн гэрчилгээний хуваарилалт, олголт, бичилт, хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

4.12. Гэрчилгээ олгосон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо, хэмжээний талаарх мэдээллийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын газар тариалангийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Хүнс, хөдөө аж ахуйн яаманд цахимаар болон албан тоотоор жил бүр хүргүүлж, эдээллийн сан бүрдүүлнэ.

4.13. Хэрэглэгчдэд ургамал, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой хүссэн мэдээ, мэдээллийг нээлттэйгээр өгч байх үүргийг сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээнэ.

Тав. Анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч, ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулагч иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.1. Анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч нь “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 129 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах заавар”-ын дагуу харъяа мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.

5.2. Энэхүү бүртгэлийн дугаарыг авахдаа иргэн, хуулийн этгээд нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын цахим маягыг (www.fsi.gov.mn) веб сайтаас татан авч, нэвтрэх цонхны “хэрэглэгч” гэсэн хэсэгт USER. “нууц үг” гэсэн хэсэгт 123456 гэж бичиж бүртгүүлнэ.

5.3. Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн явцад тээвэрлэгч нь авто тээврийн шалган бүртгэх нэгжийн шаардлагаар гарал үүслийн гэрчилгээг шалгуулах үүрэгтэй бөгөөд стандартын дагуу тээвэрлэнэ.

5.4. Орон нутгаас олгосон гэрчилгээг дахин ашиглах, засварлах, хуурамчаар үйлдэхийг хориглоно.

5.5. Гэрчилгээ олгохтой холбогдсон асуудлаар холбогдох дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

5.6. Гэрчилгээгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдсан болон тээвэрлэсэн этгээд нь түүнтэй холбогдон гарсан бүх хариуцлагыг хүлээнэ.

5.7. Өөрийн өмчлөл, эзэмшлийн талбайг аливаа иргэн хуулийн этгээдэд албан ёсны гэрээгүй ашиглуулж тариалсан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар гарсан аливаа зөрчлийн хариуцлагыг тухайн газрыг өмчлөгч, эзэмшигч хүлээнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бүх шатны газар тариалан, ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч холбогдох хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулна.

6.2.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд улсын байцаагч холбогдох материалыг бүрдүүлэн хуулийн байгууллагад шилжүүлнэ.

-----oOo-----

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015
оны 8 дугаар сарын 24-ны өдрийн

А-105 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

УРГАМАЛ, ТҮҮНИЙ ГАРАЛТАЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ
ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ГАРАЛ, ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ №

Код 1													
Аймаг, Нийслэл		Сум, Дүүрэг		Баг, Хороо		Анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч					Ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн		
6	5	0	1	5	1	2	6	8	4	5	1	1	

Ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний таримлын код	Хэмжих нэгж	Худалдах тоо хэмжээ	Борлуулах		Бо /ху/
			Хүнс /НВ/	Үйлдвэрийн түүхий эд /НТ/	

2. Эрдэс бордоо хэрэглэсэн эсэх, хэрэглэсэн бол бордооны нэр
. 1га-д хэрэглэсэн хэмжээ /үйлчлэх бодисоор/ кг.

3. Ургамал хамгаалах бодис хэрэглэсэн эсэх, хэрэглэсэн бол бодисын нэр
..... 1 га-д хэрэглэсэн хэмжээ /үйлчлэх бодисоор/кг

4. Өсөлтийн бодис хэрэглэсэн эсэх, хэрэглэсэн бол түүний нэр
..... хэрэглэсэн тун

5. Түүхий эд, бүтээгдэхүүн, таримлын үр, суулгацанд хийсэн мэдрэхүйн
үзлэгийн дүн

6. Түүхий эд, бүтээгдэхүүн, таримлын үр, суулгацанд хийсэн лабораторийн
шинжилгээний дүн

.....
.....

7. Тээврийн хэрэгслийн Улсын дугаар

Жолоочийн нэр утас.....

8. Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг бөөнөөр нь
шууд худалдан авах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр
.....

9. Гэрчилгээ олгосон мэргэжилтэн: / /

20 ... оны ... сарын ... өдөр

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015
оны 8 дугаар сарын 24-ны өдрийн

А-105 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

ТАРИМЛЫН КОД

Таримлын код			
Таримлын код	1. Үр тариа	буудай	1.1

		арвай	1.2
		овъёос	1.3
		хөх тариа	1.4
		Тэжээлийн таримал	1.5
		бусад	1.6
	2. Төмс		2.
	3 Хүнсний ногоо	байцаа	3.1
		лууван	3.2
		манжин	3.3
		урт сонгино	3.4
		бөөрөнхий сонгино	3.5
		сармис	3.6
		лооль	3.7
		хэмх	3.8
		бусад	3.9
	4. Буурцагтан	шар буурцаг	4.1
		вандуй	4.2
		бусад	4.3
	5 Тос, техникийн ургамал	рапс	5.1
		гич	5.2
		наранцэцэг	5.3
		чихрийн манжин	5.4
		бусад	5.5
	6 Жимс, жимсгэнэ	чацаргана	6.1

		үхэр нүд	6.2
		бөөрөлзгөнө	6.3
		гүзээлзгэнэ	6.4
		алим	6.5
		интоор	6.6
		Бусад	6.7
	7. Байгалийн ургамал	Хадлан	7.1
		мөөг	7.2
		самар	7.3
		жимсгэнэ	7.4
		бусад	7.5
	8.Бусад		8.1
Таримлын үр, суулгац	9. Үр тариа , тэжээлийн таримлын үр	Буудай	9.1
		Арвай	9.2
		Овьёос	9.3
		хөх тарианы	9.4
		Тэжээлийн тарималын	9.5
		Бусад	9.6
	10. Төмсний үр	Төмс	10
	11. Хүнсний ногооны үр	байцаа	11.1
		лууван	11.2
		манжин	11.3
		урт сонгино	11.4
		бөөрөнхий сонгино	11.5
		сармис	11.6

		лооль	11.7
		хэмх	11.8
		бусад	11.9
	12. Буурцагтны үр	шар буурцаг	12.1
		вандуй	12.2
		бусад	12.3
	13. Тос техникийн ургамлын үр	рапс	13.1
		гич	13.2
		наранцэцэг	13.3
		чихрийн манжин	13.4
		бусад	13.5
	14. Жимс, жимсгэний суулгац	чацаргана	14.1
		үхэр нүд	14.2
		бөөрөлзгөнө	14.3
		гүзээлзгэнэ	14.4
		алим	14.5
		интоор	14.6
		бусад	14.7
	15. Бусад үр		15.1

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015
оны 8 дугаар сарын 24-ны өдрийн

А-105 дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт

ТАЛБАЙН ТҮҮХИЙН ДЭВТЭР

Талбайн бүртгэлийн дугаар....., хэмжээга

Уг талбайг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн

овог нэр

Талбайд хийгдсэн ажил	2015	2016	2017	2018	2019	2020	
Тарьсан таримлын нэр							
Тарьсан хугацаа:							

Хураасан сар, өдөр							
Ургац, ц/га							

Тухайн талбайд хийсэн арчилгаа:							
Хийсэн арчилгааны төрөл, он		2015	2016	2017	2018	2019	2020
Эрдэс бордоо:	нэр:						
	хэрэглэсэн сар, өдөр:						
	1га-ийн тун:						
Шим бордоо:	нэр:						
	хэрэглэсэн сар, өдөр:						
	1га-ийн тун:						
Ургамлын өсөлтийн гармон:	нэр:						
	хэрэглэсэн сар, өдөр:						
	1га-ийн тун:						
Тухайн жилд гарсан гол хөнөөлт шавж:	нэр:						
Хэрэглэсэн инсектоцид, биобэлдмэл:	нэр:						
	хэрэглэсэн сар, өдөр:						
	1га-ийн тун:						

Үрийн ариутгалд хэрэглэсэн бодис:	нэр:							
	хэрэглэсэн сар, өдөр:							
	нэгжид хэрэглэсэн тун:							
Хэрэглэсэн гербицид:	нэр:							
	хэрэглэсэн сар, өдөр:							
	1га-ийн тун:							
Тархсан өвчин:	нэр:							
Өвчинтэй тэмцэхэд хэрэглэсэн фунгицид, биобэлдмэл	нэр:							
	хэрэглэсэн сар, өдөр:							
	1га-ийн тун:							
Усалсан эсэх, усалсан бол	1га-ийн тун:							
	хэдэн удаа усалсан:							
Уриншийн төрөл:								
Хагалсан	гүн,см							
Хавсан	гүн, см							
Хэрэглэсэн гербицид:	нэр							
	хэрэглэсэн сар, өдөр:							
	1га-ийн тун:							

Талбайн түүхийг бичсэн хүний нэр						
Албан тушаал :						

Тайлбар: Бордоо, ургамал хамгааллын бодис /хог ургамал, хортон шавьж, өвчинтэй тэмцэх зорилгоор хэрэглэсэн/ хэд хэдэн удаа хэрэглэсэн бол тухай бүрийг хэрэглэсэн тун, хугацааг бичнэ.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015
оны 8 дугаар сарын 24-ны өдрийн

А-105 дугаар тушаалын 5 дугаар
хавсралт

УРГАМАЛ, ТҮҮНИЙ ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНД ГАРАЛ ҮҮСЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХОД БАРИМТЛАХ ХУГАЦАА

А. Үр тариа

№	Түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Борлуулах газар/хоног/			
		Гурилын үйлдвэрт	Тэжээлийн үйлдвэрт	Спиртийн үйлдвэрт	Ү
1	Үр тариа	200	200	200	

Б. Төмс

№	Түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Борлуулах газар/хоног/
---	----------------------------------	------------------------

		Дэлгүүр, нийтийн хоолны газарт	Бөөний худалдаанд /зориулалтын агуулахтай/	Спиртийн үйлдвэрт	
1	Эрт ургацын	10	20	-	
2	Оройн ургацын	20	30	40	
3	Үрийн төмс	-	-	-	

В. Хүнсний ногоо

№	Түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Борлуулах газар/хоног/		
		Дэлгүүр, нийтийн хоолны газарт	Бөөний худалдаанд	Боловсруулалтын үйлдвэрт
1	Шинэ ургацын савлаагүй ногоо	15	30	20
2	Нөөшилсөн ногоо	60	60	-
3	Вакуум савлагаатай ногоо	20	40	-
4	Хатаасан ногоо	90	120	-
5	Тарвас	15	25	15
6	Амтат гуа	20	30	15
7	Навчит ногоо	10	15	10
8	Таримал болон байгалийн мөөг	10	15	10
9	Хүнсний ногооны үр	60	60	-

Г. Жимс, жимсгэнэ

№	Түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Борлуулах газар/хоног/		
		Дэлгүүр, нийтийн хоолны газарт	Зориулалтын агуулахтай бөөний худалдаанд	Боловср үйлдв
1	Шинэ ургацын савлаагүй жимс /бэсрэг, давжаа, торниун алим, чавга/	30	50	20
2	Савлаагүй жимсгэнэ /үхэр нүд бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ/	5	10	7
3	Жимсгэний чанамал	40	60	-
4	Хушны самар /цайруулж хуурсан/	50	100	10

Д. Тэжээл, тэжээлийн ургамал

№	Түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Борлуулах газар/хоног/	
		Иргэдэд	Улс, аймаг, сумын
1	Байгалийн хадлан /задгай/	30	40
2	Байгалийн хадлан боосон	100	150
3	Таримал тэжээлийн өвс /боосон/	100	150
4	Тэжээлийн ургамлын үр	60	60

